



БАТЛАВ.



НИЙЛҮҮЛЭГЧ

Медклиин ХХК
ЗАХИРАЛ


Ц.ГАНТӨМӨР

ЭНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
НИЙЛЧЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,
АРИУТГАЛЫН БОДИС, ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 68

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас
Медклиин ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож
20 оны 02 дугаар сарын 21-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх)
хуулав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа,
бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх
харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү
гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь ариутгалын бодис худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх)
8,124,000 (найман сая нэг зуун хорин дөрвөн мянган) төгрөгөөр (цаашид
“гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр
хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Барааны нэр, төрөл	Багц ийн дуга а	Үйлдвэрлэг ч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
Скинман софт 500 мл	28	Герман	Ш	677	12000	8,124,000

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 8,124,000 (найман сая нэг зуун хори дөрвөн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөө 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 1. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаа	Урьдчилгаа /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/
1	Скинман софт 500 мл	28		8,124,000
	Нийт дүн			

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтөд.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

йлчлэх
үрээ

арааны
ирал

үслийн улс

- 2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.
- 3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно

23	ГЕН-ийн 23-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
24	Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 24)
24	ГЕН-ийн 24-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
25	Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)
25	ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
26	Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)
26	ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
27	Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)
27.1	Монгол хэл
28	Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)
28.1	Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө
29	Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)
29.1	Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2
30	Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)
30	Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
.....Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
.....Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
.....Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
.....Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бичиг
.....Х.Ариунтуяа

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Медклиин ХХК-ийн Менежер
.....Т.Сувд-Эрдэнэ

Хаяг: Энэрэл төв, 3 давхар Баянзүрх дүүрэг, Улаанбаатар
Утас: 77002120, 96889964

Регистрийн дугаар:5595088
Банк: Голомт
Дансны дугаар: 1605020366

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн
Мэргэжилтэн

..........Д.Мөнхцэцэг

14210 Улаанбаатар хот Сүхбаатар
дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын
VIII байр

Утас:263695